



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: 3АА-2025/177/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улиастай сум
2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа
Утас: 99993365
Цахим хаяг: Bat-Undraa@audit.gov.mn
Аудитын менежер: Х.Болдбаатар
Утас: 99105506
Цахим хаяг: Boldbaatarkh@audit.gov.mn
Хаан соёмбо аудит ХХК -гэрээт аудитор:
Б.Цэрэндэжид
Утас: 99812811
Цахим хаяг: tserendejid1109@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Утас: 11101-41000000
Утас: 11101-41000000
11101-41000000

2025.02.21 ө. 213

Тайлбар

Утас

ЦАГААНХАЙРХАН СУМЫН
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Л.ЛХАГВАСҮРЭН-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилт 95.7 хувьтай дүгнэгджээ. Цэцэрлэгийн 60 жилийн ойн хүрээнд иргэдийн хандиваар 2,260.1 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн байна.

Аудитын гол асуудал

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 90 нэр төрлийн 47,258.7 мянган төгрөгийн үлдэх өртөггүй хөрөнгийг дахин үнэлж ашиглах хугацааг сунгаагүй, хүүхдийн хоолыг нормативт зардлаас 351.9 мянган төгрөг дутуу олгосон, 2,343.2 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нь Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 5,674.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмж нийлүүлэгдсэнийг

Ойршил/Албан бичиг/Дүгнэлт

812507366

данс бүртгэлд тусгасан байна тус цэцэрлэг нь Цагаанхайрхан сумын иргэдийнТөлөөлөгчдийн Хурлын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 32дугаар тогтоолоор 1,220.6 мянган төгрөгийн тавилга эд хогшил, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/45 дугаар захирамжаар 4,342.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 250.0 мянган төгрөгийн программ хангамжийг акталж, данс бүртгэлээс хассан байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Д.БАТ-УНДРАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Байгууллагын нэр: Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	100,980,997.90	112,178,453.26
31	МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	34,561,845.50	52,741,964.50
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	34,561,845.50	52,741,964.50
3121	Төгрөг	34,561,845.50	52,741,964.50
31211	Төрийн сангийн харилцах	34,561,845.50	52,741,964.50
35	БАРАА МАТЕРИАЛ	66,419,152.40	59,436,488.76
351	Түүхий эд материал	554,000.00	165,000.00
35130	Эм боох материал	554,000.00	165,000.00
354	Хангамжийн материал	63,608,152.40	59,271,488.76
35410	Бичиг хэргийн материал	185,500.00	185,500.00
35420	Аж ахуйн материал	2,720,100.00	3,126,400.00
35430	Сэлбэг хэрэгсэл	918,000.00	918,000.00
35450	Барилгын засварын материал	477,500.00	477,500.00
35460	Хүнсний материал	6,472,020.00	4,620,949.00
35470	Бусад хангамжийн материал	52,835,032.40	49,943,139.76
35600	Мал, амьтад	2,257,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	731,515,775.58	706,447,924.15
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	731,515,775.58	706,447,924.15
392	Биет хөрөнгө	723,026,775.58	698,288,924.15
39201	Барилга, байгууламж	670,554,230.00	670,554,230.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(76,974,230.24)	(89,594,230.28)
39205	Машин, тоног төхөөрөмж	54,205,197.40	57,627,517.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	(37,886,009.68)	(38,837,411.15)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	30,612,450.48	28,541,346.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	(22,962,242.08)	(22,951,029.14)
39214	Бусад үндсэн хөрөнгө	129,536,926.00	123,526,558.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(24,839,846.30)	(30,578,057.18)
39217	Номын фонд	780,300.00	-
393	Биет бус хөрөнгө	8,489,000.00	8,159,000.00
39301	Програм хангамж	1,900,000.00	1,650,000.00
39302	Хасагдуулга	(1,405,000.00)	(1,485,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	7,994,000.00	7,994,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	832,496,773.48	818,626,377.41
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	832,496,773.48	818,626,377.41
51	Засгийн газрын хувь оролцоо	832,496,773.48	818,626,377.41
511	Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан	37,707,959.81	37,707,959.81
51101	Өмч: -Төрийн өмч	37,707,959.81	37,707,959.81
512	Хуримтлагдсан үр дүн	791,676,231.67	777,805,835.60
51210	Өмнөх үеийн үр дүн	791,676,231.67	791,676,231.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	(13,870,396.07)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	3,112,582.00	3,112,582.00
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН	832,496,773.48	818,626,377.41

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Байгууллагын нэр: Цагаанхайрхан сумын хүүхдийн
цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	297,227,639.00	387,987,040.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	13,862,439.00	9,139,640.00
120	Нийтлэг татварын бус орлого	13,862,439.00	9,139,640.00
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	13,862,439.00	9,139,640.00
120004			
4	Бараа материалын үнэгүй орлого	4,172,000.00	1,225,300.00
120004			
5	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	9,690,439.00	7,914,340.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,365,200.00	378,847,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	259,058,400.00	342,558,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,058,400.00	342,558,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,827,000.00	9,603,000.00
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан		
131104	төсвөөс доод шатны төсвийн захи	2,827,000.00	9,603,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,479,800.00	26,685,600.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн		
132001	төсөвт байгууллага/	21,479,800.00	26,685,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	300,745,631.73	400,674,785.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ	300,745,631.73	400,674,785.40
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	300,745,630.74	400,673,373.08
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	184,561,227.00	260,286,039.00
210101	Цалин	117,187,309.00	159,106,196.00
210102	Нэмэгдэл цалин	62,332,643.00	94,698,483.00
210104	Урамшуулал	5,041,275.00	6,481,360.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,114,742.00	30,327,295.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,129,442.00	22,733,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,746,600.00	2,024,883.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,397,000.00	334,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	349,100.00	380,212.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,492,600.00	4,854,200.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,061,799.01	25,684,187.68
210301	Гэрэл цахилгааны зардал	4,698,407.01	5,662,239.68
210302	Түлш, халаалтын зардал	15,201,192.00	19,211,148.00
210303	Цэвэр, бохир усны зардал	162,200.00	810,800.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,660,000.00	-
210408	Бараа материал актасны зардал	2,660,000.00	-
2105	Нормативт зардал	28,040,440.00	27,921,988.00
210502	Хоол	28,040,440.00	27,921,988.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр		
2108	хураамж	493,500.00	853,050.00

210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	493,500.00	853,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,813,922.73	54,600,813.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	8,827,764.50	20,231,872.64
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,480,600.00	2,569,400.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	31,505,558.23	31,799,540.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.99	1,412.32
	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад		
2134	олгох татаас, санхүүжилт	0.99	1,412.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.99	1,412.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	(3,517,992.73)	(12,687,745.40)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,182,650.67
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,182,650.67
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VI=IV-V)	-	(1,182,650.67)
5	НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI)	(3,517,992.73)	(13,870,396.07)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Байгууллагын нэр: Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	283,365,200.00	378,847,400.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	283,365,200.00	378,847,400.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	259,058,400.00	342,558,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	259,058,400.00	342,558,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,827,000.00	9,603,000.00
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан		
131104	төсвөөс доод шатны төсвийн захи	2,827,000.00	9,603,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,479,800.00	26,685,600.00
	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон		
132001	нутгийн төсөвт байгууллага/	21,479,800.00	26,685,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	264,017,823.50	360,667,281.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	264,017,823.50	360,667,281.00
210	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,017,822.51	360,665,868.68
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	184,561,227.00	260,286,039.00
210101	Үндсэн цалин	117,187,309.00	159,106,196.00
210102	Нэмэгдэл	62,332,643.00	94,698,483.00
210104	Үр дүнгийн урамшуулал	5,041,275.00	6,481,360.00
2102	Ажил олгочоос нийгтийн даатгалд төлөх шимтгэл	22,114,742.00	30,327,295.00
210201	Тэтгэврийн даатгалын шимтгэл	15,129,442.00	22,733,800.00
210202	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,746,600.00	2,024,883.00
210203	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	1,397,000.00	334,200.00
210204	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	349,100.00	380,212.00
210205	Эрүүл мэндийн даатгалын хураамж	3,492,600.00	4,854,200.00
2103	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	20,479,799.01	25,684,187.68
210301	Гэрэл цахилгааны зардал	4,698,407.01	5,662,239.68
210302	Түлш, халаалтын зардал	14,701,192.00	19,211,148.00
210303	Цэвэр, бохир усны зардал	1,080,200.00	810,800.00
2105	Нормативт зардал	23,199,690.00	22,588,617.00

210502	Хоол, хүнс	23,199,690.00	22,588,617.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,000,000.00	1,000,000.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	493,500.00	853,050.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	493,500.00	853,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,168,864.50	19,926,680.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,688,264.50	17,406,780.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дэдлаг хийх	1,480,600.00	2,519,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.99	1,412.32
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.99	1,412.32
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.99	1,412.32
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	19,347,376.50	18,180,119.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	19,347,376.50	18,180,119.00
9	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эхний үлдэгдэл	15,214,469.00	34,561,845.50
10	Мөнгө, түүнтэй адилгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	34,561,845.50	52,741,964.50

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Байгууллагын нэр: Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцооны дүн
0	ДАНС	511	51300	51210+51220	
2	2023 оны 1-р сарын 1-ээрх үлдэгдэл	37707959.81	1254230.00	795194224.40	834156414.21
3	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
4	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37707959.81	1254230.00	795194224.40	834156414.21
5	Дахин үнэлгээний нэмэгдэл, хэрэгжсэн дүн				
6	Хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний гарз				
7	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				
8	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/			-3517992.73	-3517992.73
9	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	37707959.81	3112582.00	791676231.67	832496773.48
10	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	37707959.81	3112582.00	791676231.67	832496773.48
11	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
12	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	37707959.81	3112582.00	791676231.67	832496773.48
13	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
14	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт				
15	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз гарз				

16	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү				
17	Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/	0	0	-13870396.07	-13870396.07
18	2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	37707959.81	3112582.00	777805835.60	818626377.41

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Байгууллагын нэр: Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,561,845.50	(34,561,845.50)	-
2	I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	384,414,600.00	323,533,691.00	60,880,909.00	84.16
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	384,414,600.00	323,533,691.00	60,880,909.00	84.16
210	Бараа, үйлчилгээний зардал	384,414,600.00	323,533,691.00	60,880,909.00	84.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	301,460,500.00	260,286,039.00	41,174,461.00	86.34
210101	Үндсэн цалин	197,826,400.00	159,106,196.00	38,720,204.00	80.43
210102	Нэмэгдэл	100,572,700.00	94,698,483.00	5,874,217.00	94.16
210104	Урамшуулал	3,061,400.00	6,481,360.00	(3,419,960.00)	211.71
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	35,554,600.00	30,327,295.00	5,227,305.00	85.30
210201	Тэтгэврийн даатгал	24,177,600.00	22,733,800.00	1,443,800.00	94.03
210202	Тэтгэмжийн даатгал	2,843,900.00	2,024,883.00	819,017.00	71.20
210203	ҮОМШӨ ний даатгал	1,422,200.00	334,200.00	1,088,000.00	23.50
210204	Ажилгүйдлийн даатгал	1,422,200.00	380,212.00	1,041,988.00	26.73
210205	Эрүүл мэндийн даатгал	5,688,700.00	4,854,200.00	834,500.00	85.33
2105	Нормативт зардал	24,115,100.00	22,588,617.00	1,526,483.00	93.67
210501	Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	-	-	-	-
210502	Хоол, хүнс	24,115,100.00	22,588,617.00	1,526,483.00	93.67
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	859,800.00	853,050.00	6,750.00	99.21
210806	Мэдээллийн технологийн зардал	859,800.00	853,050.00	6,750.00	99.21
2201	Бараа үйлчилгээний бусад зардал	22,424,600.00	9,478,690.00	12,945,910.00	42.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	19,904,700.00	6,958,790.00	12,945,910.00	34.96
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,519,900.00	2,519,900.00	-	100.00
	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	-	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	-	-	-
213209	Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	-	-	-	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	384,414,600.00	352,161,800.00	32,252,800.00	91.61
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	343,684,900.00	342,558,800.00	1,126,100.00	99.67
131001	Улсын төсвөөс санхүүжих	343,684,900.00	342,558,800.00	1,126,100.00	99.67
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	30,685,700.00	-	30,685,700.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-
1200043	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	30,685,700.00	-	30,685,700.00	-
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	10,044,000.00	9,603,000.00	441,000.00	95.61
	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,044,000.00	9,603,000.00	441,000.00	95.61
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	34,561,845.50	(34,561,845.50)	-

5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	52,741,964.50	(52,741,964.50)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.00	11.00	1.00	91.67
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4.00	3.00	1.00	75.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
64	ЭМЧЛҮҮЛЭГСЭДИЙН ТОО	-	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	11.00	1.00	91.67
	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч				
650004	ЛҮБД/	5.00	5.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ГҮ/	7.00	6.00	1.00	85.71

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Байгууллагын нэр: Цагаанхайрхан сумын хүүхдийн цэцэрлэг

Тайлант хугацаа: 2024.12.31

НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Д/Д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү дүн	Харьцуулалт
2	1. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	26,685,600.00	26,684,187.68	1,412.32	99.99
21	УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	26,685,600.00	26,684,187.68	1,412.32	99.99
210	Бараа, үйлчилгээний зардал	26,685,600.00	26,684,187.68	1,412.32	99.99
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	25,685,600.00	25,684,187.68	1,412.32	99.99
210301	Гэрэл цахилгаан	5,093,000.00	5,662,239.68	(569,239.68)	111.18
210302	Түлш, халаалт	19,892,600.00	19,211,148.00	681,452.00	96.57
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	810,800.00	(110,800.00)	115.83
2106	Эд хогшил худалдан авах	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
210604	Урсгал засвар	1,000,000.00	1,000,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	26,685,600.00	26,685,600.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	26,685,600.00	26,685,600.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	26,685,600.00	26,685,600.00	-	100.00
	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ				
120004	АЖИЛЛАГААНААС	-	-	-	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	-
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	0.00	(0.00)	-
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	-	-

62	АЖИЛЛАГСДЫН ТОО	12.00	11.00	1.00	91.67
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	4.00	4.00	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00	-	100.00
620004	Гэрээт ажилтан	4.00	3.00	1.00	75.00
63	СУРАЛЦАГЧДЫН ТОО /жилийн дунджаар/	-	-	-	-
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	12.00	11.00	1.00	91.67
650004	СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч /ТҮБД/	5.00	5.00	-	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч /ТҮ/	7.00	6.00	1.00	85.71

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагааны чиглэл:

- *Сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээ*

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхэм зорилго:

"Хүүхдээ дээдэлж,багшаа хөгжүүлж чанартай сургалтыг эрхэмлье" зорилгыг тавин ажиллаж байна.

2024 онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 7 зорилтын хүрээнд 63 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг улирал тутам гаргаж, эрх бүхий албан тушаалтнаар дүгнүүлэн ажилласан байна. Төлөвлөгөөний гүйцэтгэлийн биелэлт 95.7 хувьтай байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
9. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд орсон өөрчлөлт: 2024 оны 03 сарын 27-ны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тотоосон, Боловсролын ерөнхий хууль 2024 оны 07-р сарын 07-нд батлагдсан. Засгийн газрын 2024 оны 08 сарын 28-ны 53 дугаар тогтоолоор "Хувьсах зардлыг хэмжээ, итгэлцүүр" шинэчлэгдэн батлагдсан, Сангийн Сайдын 2024 оны 04 сарын 01-ний А/52 тушаалаар дотоод албан томилолтын зардлын хэмжээг шинэчлэн баталсан. Мөн Засгийн газрын 2024 оны 05 сарын 29-ний 237 дугаар тогтоолоор "Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын хэмжээг шинэчлэн тогтоосон.

Байгууллагын дотоод хяналтын талаар: Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Дотоод хяналтын багийг байгуулж, төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна. Мөн Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд цэцэрлэгийн эрхлэгч, санхүүгийн албаны дарга, төсөв, төрийн сангийн мэргэжилтэн нар хяналтыг хийж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 13,870.4 мянган төгрөгөөр буюу 1.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган

төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	0.00	0.00	0.00
Бараа материал	66,419.2	59,436.4	6,982.7
Үндсэн хөрөнгө	731,515.8	706,447.9	-25,067.9
Нийт хөрөнгө	832,496.8	818,626.4	-13,870.4
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	832,496.8	818,626.4	-13,870.4
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	832,496.8	818,626.4	-13,870.4

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

Тайланд онд:

Бараа материалын эхний үлдэгдэл 66,419.2 мянган төгрөг, төсвийн хөрөнгөөр 41,416.2 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, 1,225.3 мянган төгрөгийн бараа материал үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 47,335.2 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 2,289.0 мянган төгрөгийн бараа материал акталж эцсийн үлдэгдэл 59,436.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,982.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгийн хувьд хөрөнгө оруулалтаар 7,914.3 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүйгээр нэмэгдэж, 13,603.8 мянган төгрөгийн хөрөнгийг шийдвэрийн дагуу акталж, жилийн эцэст 889,893.7 мянган төгрөгийн хөрөнгийн үлдэгдэлтэй байна. Тайлант оны элэгдлийн зардалд 31,799.5 мянган төгрөгийг тооцож бүртгэсэн байна.

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ 13,870.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй шууд холбоотой болно.

Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 343,684.9 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 26,685.6 мянган төгрөг, үйл ажиллагааны орлогоос 10,044.0 мянган төгрөг нийт зарлагыг 380,414.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 26,685.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 342,558.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 9,603.0 мянган төгрөгийг бусад үйл ажиллагааны орлогоос төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 360,667.3 мянган төгрөг буюу 94.8 хувьтай байна. Энэ нь цалин нийгмийн даатгалын шимтгэл зэрэг зардлыг хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган

төгрөгөөр/

Хөтөлбөр арга хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
71801/80109	Тогтмол зардал	26,685.6	26,685.6	0.0	100%
71801/80233	Хүүхэд хамгаалал	381.0	381.0	0.0	100%
71801/81605	Эрүүл мэндийг дэмжих	581.5	500.0	81.5	86%
71801/81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоол	23,283.5	22,509.3	774.2	96.7%
71801/81816	Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	1,494.5	1,494.5	0.0	100%
71801/81823	Боловсролын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх	581.5	0	581.5	0%
71801/81832	Нүүдлийн бүлэгт хамруулах	3,757.2	1,084.1	2,673.1	28.9 %
71801/81833	Явуулын багшийн үйлчилгээ	9,801.0	2,450.3	7,350.7	25%
71801/81834	Боловсролын стандарт сургалтын орчин	303,388.9	296,893.9	6,495.0	97.9%
71801/81844	Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн	10,044.0	8,668.6	1,375.4	86.3%
НИЙТ		379,998.7	360,667.3	19,331.4	94.9 %

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 26,685.6 мянган төгрөгийн орлого төвлөрүүлснээс гүйцэтгэлээр 26,685.6 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, түлш халаалт, цэвэр бохир ус, урсгал засварын зардалд зарцуулсан байна.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

Тайлант онд худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй шууд худалдан авалтыг хийсэн байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг “Хаан соёмбо аудит ХХК”-ны гэрээт аудитор Б.Цэрэндэжид гүйцэтгэж, анхан шатны хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд хийж, чанарын хяналтыг аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дүгээр сарын 03-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг 400,674.8 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8,013.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 6,410.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Цагаанхайрхан сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар зөрчилгүй санал дүгнэлт өгсөн бөгөөд зөвлөмж өгөөгүй, акт албан шаардлага аваагүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татсан асуудал байгаагүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 2695.1 мянган төгрөгийн алдаа зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа:

Байхгүй

Шийдвэрлэсэн байдал: Байхгүй

5.1 Төлбөрийн акт тогтоогоогүй

5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй

5.3 Зөвлөмж

Илэрсэн алдаа: Хүүхдийн хоолыг нормативт зардлаас 251.9 мянган төгрөгөөр дутуу зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх" заалт, Засгийн газрын 2019 оны 450, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг хэрэгжүүлэн ажиллах

Илэрсэн алдаа: Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй 9 төрлийн 9,144.7 мянган төгрөгийн хөрөнгө элэгдээрээ анхны өртгөө нөхсөн үлдэгдэл өртөггүй хөрөнгө бүртгэлтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4-д "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах", ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 7.1-д "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Дахин үнэлгээ хийх шалгуур хангасан хөрөнгөнд үнэлгээ хийж бүртгэлд тусгах, цаашид ашиглах боломжгүй хөрөнгүүдийг холбогдох газрын зөвшөөрлийн дагуу данснаас хасах арга хэмжээ авч, үндсэн хөрөнгийн бүртгэлийг цэгцлэх;

Илэрсэн алдаа: Гэрэл цахилгааны зардлаас 2343.2 мянган төгрөгийг бараа материалд гүйлгэн зарцуулсан.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2. батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах; Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ыг, батлагдсан төсвийн дагуу эдийн засгийн ангилалаар зардал гаргах, хууль, журмыг мөрдөж ажиллах, хяналтыг хэрэгжүүлэх талаар зөвлөмж өглөө.

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшингөөс бага байгаа тул "Өөрчлөлтгүй" дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БҮРҮҮ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн өсүүдэд	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хүүхдийн хоолны нормативт зардлаас дутуу олгосон	1	351.9					1	351.9				
Анхны өртгөө элэгдлээрээ нөхсөн 0 үлдэгдэлтэй байгаа 90 нар төрлийн 47,258,729.00 төгрөгийн хөрөнгийг дахин үнэлж ашиглалтын хугацааг сунгах зардлыг эдийн засгийн ангиллаар зарцуулаагүй байна.	1	2343.2					1	2343.2				
Дүн		2695.1					2695.1					

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-02-06

БОЛОВСРУУЛСАН:

“ХААН СОЁМО АУДИТ” ХХК ГЭРЭЭТ АУДИТОР

Огноо: 2025-02-06

Б.ЦЭРЭНДЭЖИД